



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/02

Улаанбаатар хот

Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг
худалдаж авах эрхийг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны А/186 дугаар захирамжаар 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн нээлттэй дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулахад 1 дүгээр хороо, Өндөртолгой, Онцгой байдлын хэлтсийн хойд талд байршилтай 0.0115 га газрын эзэмших эрхийн ялагчаар шалгарсан Б.Цогжавхлан нь үлдэгдэл төлбөр болох 27.824.200 төгрөг, 1 дүгээр хороо, Үйлдвэрийн бүсэд байршилтай 0.0475 га газрын эзэмших эрхийн ялагчаар шалгарсан Д.Алтанчимэг нь үлдэгдэл төлбөр болох 9.063.000 төгрөг, 1 дүгээр хороо, Үйлдвэрийн бүсэд байршилтай 1 га газрын ашиглах эрхийн ялагчаар шалгарсан “Монгол 8888” ХХК нь үлдэгдэл төлбөр болох 52.420.000 төгрөг, 2 дугаар хороо, Замчин гэр хорооллын баруун урд талд байршилтай 0.0258 га газрын эзэмших эрхийн ялагчаар шалгарсан Д.Цэвэгдорж нь үлдэгдэл төлбөр болох 25.528.640 төгрөг, 2 дугаар хороо, Билгүүт байршилтай 0.3011 га газрын эзэмших эрхийн ялагчаар шалгарсан Ц.Пүрэвсүрэн нар нь үлдэгдэл төлбөр болох 54.651.880 төгрөгийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу хугацаандаа төлөөгүй тул газар эзэмших эрхийн гэрчилгээг худалдаж авах эрхийг цуцлан, дэнчинд төлсөн мөнгийг Улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг худалдаж авах эрхийг хүчингүй болгосонтой холбогдуулан дээрх байршилд хууль, журмын дагуу дуудлага худалдааг дахин зохион байгуулахыг Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД